

Ажлын хуудсанд өгөгдөл оруулах

Таны боловсруулах хүснэгтэн мэдээлэл текстэн ба тоон өгөгдлүүдээс бүрдэнэ.

Нүдний өгөгдлүүд

Нүдэнд **тогтмол өгөгдлүүд** ба **томъёо** гэсэн хоёр төрлийн мэдээллийг оруулж болно.

Тогтмол өгөгдлүүд. Тоон утга, текст, огноо, цаг хугацаа зэрэг мэдээллийг тогтмол өгөгдлүүд гэнэ. Тоон утга зөвхөн цифр агуулдаг бол текстийн өгөгдөл нь Улаанбаатар-49 гэх мэт үсэг, цифр болон бусад дурын тэмдэгтүүдийг агуулсан байж болно.

Томъёо. Тэнцүүгийн тэмдгээр эхэлсэн, математик үйлдлийг илэрхийлж, тооцоолол хийдэг өгөгдлийг Томъёо гэнэ. Нүдэнд томъёо оруулсан үед Excel түүний математик үйлдлийг гүйцэтгээд хариуг нь тухайн нүдэнд дотор харуулна.

Excel дээр томъёо зохиоход хэрэглэдэг үндсэн зарчим бол томъёонд нүдний хаягийг хэрэглэх явдал юм. өөрөөр хэлбэл хэрэв томъёо ямар нэгэн нүдний хаягийг агуулсан байвал бодолт хийгдэх үед хаягийнх нь оронд тухайн нүдэн дээр байгаа утгыг нь хэрэглэнэ. Жнь та A1:A5 нүднүүдэд 5-н өөр тоо оруулаад харин A6 нүдэнд эдгээр тоонуудын нийлбэрийг бодох $=A1+A2+A3+A4+A5$ гэсэн томъёог оруулбал A6 нүдэнд хариуг нь буюу эдгээр 5-н нүдэн доторх утгуудын нийлбэрийг харуулна. Ингэж томъёон дотор нүдний хаягийг хэрэглэсэн үед ямар нэг нүдний эсвэл бүх нүдний утга өөрчлөгдөхөд Excel бодолтыг дахин автоматаар гүйцэтгэж, зөв хариуг гаргаж байдаг.

Excel дээр хулгана болон товчлуурт гараар богино, хялбар томъёог хурдан зохиож болно. Харин нарийн бүтэцтэй томъёог зохиох ба хэрэглэхдээ та Excel-ийн хэрэгслийн самбарууд, илэ, функцүүдийг хэрэглэж болно. Жнь: дээрх 5-н нүдэнд байгаа тооны нийлбэрийг олох томъёо буюу илэрхийллийн оронд $=SUM(A1:A5)$ гэсэн функцийг хэрэглэж болно.

Excel-ийн тусламжтайгаар хамгийн энгийн хялбараас эхлээд хамгийн нарийн, нүсэр тооцооллыг хийхдээ та хэрхэн яаж, ямар арга замаар ажлаа хөнгөвчилж, цагаа хэмнэх вэ? Үүний тулд та 1-рт тооцоолол хийх томъёо буюу илэрхийллээ зөв зохиох, 2-рт ширдлагатай бол энэ томъёогоор бодолт нь хийгдэх нүднүүдэд томъёогоо хуулж өгөхөд болно.

Нүдэнд өгөгдөл оруулах

1. Өгөгдөл оруулах нүдийг идэвхжүүлнэ.
2. Товчлуурт гарнаас өгөгдлөө оруулна.
3. Өгөгдөл оруулж байх үед идэвхтэй нүдэн дотор босоо зураас хэлбэртэй курсор гарч ирнэ.
4. Нүдэнд өгөгдлийг оруулж дуусаад доод талынх нь нүд рүү шилжихийг хүсвэл Enter товчийг, харин баруун талынх нь нүд рүү шилжихдээ tab товчийг дарна.

Нүдэнд өгөгдлийг оруулах үйлдлийг заавал **Enter** эсвэл **tab** товчнуудын аль нэгээр дуусгах ёстой. Тэдгээр товчнуудын оронд курсор удирддаг сумтай товчнуудаас дарж болно. Хэрэв та өгөгдөл оруулж байх үедээ Esc товчийг дарвал өгөгдөл оруулах ажиллагаа хүчингүй болно.

Таныг идэвхтэй нүдэнд тогтмол өгөгдөл эсвэл томъёо оруулж эхлэнгүүт томъёоны мөр болон идэвхтэй нүд хоёрын аль алинд нь тэдгээр өгөгдлүүд харагдана. Мөн өгөгдөл оруулж эхлэхэд томъёоны мөрөн дээр гурван товч гарч ирнэ. **fx**-Insert Function-/Функц томъёо оруулах/, **✓**-Enter/Оруулах/, **✗**-Cancel/Хүчингүй болгох/ товчнууд нь товчлуурт гарны Enter ба Esc товчнуудын үүргийг гүйцэтгэнэ.

Ажлын хуудсан доторх өгөгдлүүдийн харагдах байдлыг Home [Үндсэн] таб дээрх товчнуудаар өөрчилдөг. Таныг өөрчлөх хүртэл байнга хүчинтэй байдаг, өгөгдлийг дэлгэцэн дээр харуулах Excel-ийн хэд хэдэн стандарт байдаг. Үүнд:

- Баганы стандарт өргөн нь тооны эерэг сөргийн тэмдгээс гадна 9 оронтой тоог багтаах өргөнтэй байна.
- Текстэн өгөгдлийг урт, богиноос нь хамаарахгүйгээр нүдний зүүн тал руу тэгшилж байрлуулдаг.
- Тоо, томъёог нүдний баруун тал руу тэгшилж байрлуулна.
- Тоо, томъёог нүдний өргөнд зохицуулан багтааж, хамгийн тохиромжтой хэлбэрээр нь дүрслэн харуулна.

Тоон өгөгдлүүд оруулах

Excel дээр хэд хэдэн тоон төрлийн өгөгдлийг ашигладаг. Үүнд:

- Тогтмол тоонууд
- Нүдний хаяг
- Илэрхийлэл
- Текстэн өгөгдөл

Эдгээр нь бүгд тоон өгөгдлүүд тул арифметик ба логик үйлдлүүдийг хийх үед хэрэглэж болно.

Тогтмол тоо. Excel-д тогтмол тоог дүрслэх үндсэн гурван хэлбэр байдаг. Үүнд:

- Бүхэл тоо. /1; 32; 1028; 5086/
- Бутархай тоо. /1.98; 0.22; 588.95; 4.3125/
- Экспоненциал тоо. /3.21e5; 1.256e10/

Томъёо оруулах

Идэвхтэй нүдэнд нүдний хаяг оруулна гэдэг нь томъёо оруулна гэсэн үг юм. Excel дээр томъёог заавал тэнцүүгийн (=) тэмдгээр эхлүүлдэг. Жнь: =A1+8 г.м. Тэнцүүгийн тэмдгийг товчлуурт гарнаас оруулна.

Томъёон дотор нүдний хаягийг хулганаар, товчлуурт гараар оруулж болно. Томъёоны мөрөн дээрх тэнцүүгийн тэмдгийг хэрэглэн хулганаар нүдний хаягийг оруулж болно.

Илэрхийлэл. Хэрэв та тоон өгөгдлүүд болон нүдний хаягийг хэрэглэх зарчмыг ойлгосон бол илэрхийллийн тухай бараг тал хувийг нь мэддэг боллоо гэж тооцоорой.

Арифметик илэрхийлэл. Арифметикийн операторууд гэж нэрлэдэг тусгай тэмдэгтүүдээр холбогдсон хэд хэдэн арифметикийн гишүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Тогтмол тоон утга
- Нүдний хаяг буюу тоон хувьсагч
- Өмнө нь боловсруулагдсан илэрхийллийн үр дүн байж болно.

Арифметикийн оператор бол тодорхой арифметик үйлдлийг илэрхийлсэн тусгай тэмдэг юм. Нэгээс дээш үйлдэлтэй илэрхийллээр бодолт хийх үед Excel математикт мөрддөг үйлдлийн дарааллын дүрмийг баримталдаг. Энэхүү дарааллыг хаалтны тусламжтайгаар өөрчилж болно. Хүснэгтэнд арифметикийн операторуудын тэмдэглэгээг болон бодолтонд оролцох дарааллыг нь харуулав.

Бодолтын дараалал	Операторын тэмдэглэгээ	Хийх үйлдэл
1	()	Операторуудын бодит дарааллыг өөрчилнө.
2	^	Зэрэгт дэвшүүлэх
3	*	Үржүүлэх
3	/	Хуваах
3	%	Процент /хувь/ бодох
4	+	Нэмэх
4	-	Хасах